


БАТЛАВ. МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ АУДИТОР

А.ЗАНГАД

АУДИТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ



1. Аудитын нэр

УИХ-ын Байнгын хороодоос Засгийн газарт өгсөн үүрэг, даалгавруудын хэрэгжилт

2. Аудитын код

ҮАГ-НАГ-/2014/08-НАГ

3. Аудит хийх үндэслэл, бүрэн эрх

Аудитыг УИХ-ын Төсвийн байнгын хорооны 2014 оны 1 дүгээр сарын 28-ны өдрийн “Аудитын сэдэв батлах” тухай 3 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторт 2014 онд нийлүүлэх бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний төлөвлөгөөний дагуу Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд хийнэ.

4. Аудитын зорилт

Монгол Улсын УИХ-ын Байнгын хороодоос Засгийн газарт өгсөн үүрэг даалгаврууд үр дүнтэй хэрэгжиж байгаа эсэхэд аудит хийж, дүгнэлт гарган холбогдох албан тушаалтанд танилцуулахад чиглэгдэнэ.

Энэ зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудит хийнэ. Үүнд:

- 2013 онд ерөнхий чиг үүргийн болон чиг үүргийн яамд, тохируулагч болон хэрэгжүүлэгч агентлагт өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилт, явц байдал.
- 2014 онд ерөнхий чиг үүргийн болон чиг үүргийн яамд, тохируулагч болон хэрэгжүүлэгч агентлагт өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилт, явц байдал.

5. Аудитын хамрах хүрээ

УИХ-ын Байнгын хороодоос Засгийн газар, ерөнхий чиг үүргийн болон чиг үүргийн яамд, тохируулагч болон хэрэгжүүлэгч агентлагуудад 2013-2014 онд өгсөн үүрэг, даалгавруудын хэрэгжилтийн явц, биелэлт хэрэгжилтийн дүн, ажлын тайлан мэдээ, статистик судалгаа болон холбогдох бусад баримт материалд тулгуурлан тодорхойлно.

6. Үндсэн мэдээлэл

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.3-т УИХ-ын Байнгын хороог төрийн бодлогын салбар, чиглэлээр гишүүдийн бүрэлдэхүүнтэйгээр дараах байдлаар байхаар заажээ. Үүнд:

1. Аюулгүй байдал, гадаад бодлогын;
2. Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн;
3. Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны;
4. Өргөдлийн;
5. Төрийн байгуулалтын;
6. Төсвийн;
7. Хууль зүйн;
8. Эдийн засгийн.

2014 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн байдлаар 2013-2014 онд Монгол Улсын Их Хурлын Байнгын хороодоос Засгийн газар, ерөнхий чиг үүргийн болон чиг үүргийн яамд, тохируулагч болон хэрэгжүүлэгч агентлаг, байгууллагад 2013 онд 12 тогтоолын 66 /Хавсралт 4/, 2014 онд 9 тогтоолын 78 заалт /Хавсралт 5/ нийт 21 тогтоолын 144 заалтаар үүрэг даалгавар, чиглэл өгсөн байна.

7. Эрсдэлийн үнэлгээ

Төлөвлөлтийн үе шатны ажлын явцад цуглуулж судалсан баримт, материал, хамрах хүрээ, нөхцөл байдалд хийсэн урьдчилсан дүн шинжилгээнд үндэслэн аудитын эрсдэлийн ерөнхий үнэлгээг “Дунд” гэж үзлээ.

8. Аудитын арга зүй

Аудитын явцад аудитын олон улсын стандарт, төрийн хяналт шалгалтын стандартыг мөрдөж, санхүүгийн болон гүйцэтгэлийн аудитын арга зүйг ашиглан, аудитын хөтөлбөрийн дагуу холбогдох асуудлаар аудитад хамрагдсан зарим ажилтнуудаас асуулга авах, нотлох зүйл цуглуулж, судалгаанд дүн шинжилгээ хийх зэрэг аудитын горимыг гүйцэтгэж, аудитын дүн, дүгнэлт, зөвлөмж боловсруулна.

9. Аудитад ашиглах шалгуур үзүүлэлтүүд

Аудитын зорилттой холбоотой дараах хууль тогтоомж, дүрэм, журам, зааврыг шалгуур болгон ашиглана. Үүнд:

- Монгол Улсын Үндсэн хууль,
- Монгол Улсын Их Хурлын тухай хууль,
- Засгийн газрын тухай хууль,
- Яамны эрх зүйн байдлын тухай хууль,
- Засгийн газрын агентлагын эрх зүйн байдлын тухай хууль,
- Монгол Улсын Их Хурлын Байнгын хорооны тогтоол шийдвэрүүд;
- УИХ, Засгийн газрын холбогдох шийдвэрүүд, хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан гаргасан дүрэм, журам,

- Холбогдох бусад хууль, тогтоомж.

10. Аудит хийх багийн бүрэлдэхүүн

Аудитыг Үндэсний аудитын газрын Нийцлийн аудитын газрын дарга Б.Алтанзул хянан удирдаж, тус газрын аудитын менежер З.Ариунзаяа, аудитор Г.Ганбаатар, шинжээч Б.Билэгт нар ажиллана.

11. Аудитын хугацаа

Аудитыг 2014 оны 11 дүгээр сарын 10-нд эхэлж, 2015 оны 4 дүгээр сарын 1-нд дуусгаж, 4 дүгээр сарын 10-ны дотор УИХ-д танилцуулна.

12. Аудитын тайлангийн бүтэц, түүнд тусгагдах мэдээлэл, хэлэлцүүлэх журам

Аудитын тайлан нь ерөнхий зүйл, аудитын дүн, дүгнэлт, холбогдох байгууллагын санал, аудитын зөвлөмж болон хавсралт хэсгүүдээс бүрдэнэ.

Аудитын тайлангийн төслийг Монгол Улсын Ерөнхий аудитор болон УИХ-д танилцуулж, баталгаажуулан холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлнэ.

13. Аудитад шаардагдах хөрөнгө, нөөц

- а. Боловсон хүчин: УАГ-115 өдөр*5 хүн - 575 хүн/өдөр
- б. Санхүүгийн нөөц: Цалингийн зардал: 20,125.0 мянган төгрөг
- в. Техник хэрэгсэл: Зөөврийн компьютер, дектафон, скайнер, фото аппарат болон бусад техник хэрэгсэл

Аудитын төлөвлөгөөг

Хянаж зөвшөөрсөн:


ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН
ДЭД ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.БАТТУЯА

Боловсруулсан:

НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.АЛТАНЗУЛ

АУДИТЫН МЕНЕЖЕР



З.АРИУНЗАЯА

ШИНЖЭЭЧ



Б.БИЛЭГТ